



# СОЁМБОМ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

# МЭДЭЭ

№88 /301/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.05.06

Цаг үе, үйл явдал

## БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРТ МОД ТАРИХ ӨДӨРЛӨГ БОЛОВ

Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд БХЯ, ЗХЖШ-ын бие бүрэлдэхүүн байрлалдаа мод тарих өдөрлөгийг зохион байгууллаа.

Энэ ажлын хүрээнд БХЯ-ны ойр орчимд 50 гаруй нарс, гацуур суулгаж, ногоон байгууламжаа нэмэгдүүллээ. Уг ажиллагаанд БХЯ, ЗХЖШ-ын удирдлагууд, бие бүрэлдэхүүн оролцсон юм. Энэ үеэр БХЯ, ЗХЖШ-ын ҮААХ-ийн дарга хурандаа Ж.Чогсомжав хэлэхдээ "Цаашдаа БХЯ-ны ногоон байгууламжийг сайжруулах үүднээс цэцэрлэгжүүлэлтийг ажлуудыг эрчимтэй явуулах болно. Мөн төрөл бүрийн жимс, жимсгэнийн бут, үзлэг суулгах ажил төлөвлөгдсөн" гэв.

Мөн энэ өдөр ҮБХИС-ийн бие бүрэлдэхүүн мод тарих өдөрлөгийг

зохиосон юм. Ойролцоогоор 230 гаруй багш, сонсогч, ажилтан албан хаагчид гурав хоногийн турш явагдах тус өдөрлөгөөр 4500 гаруй мод, бут тарихаар төлөвлөсөн байна.

ҮБХИС-ийн Ар талын хэлтсийн дарга хурандаа Ж.Давааноров "Тус сургуулийн хамт олон 2030 он хүртэл 180 мянган мод, бут тарихаар төлөвлөн ажиллаж байна. Энэ жил тус хөтөлбөрийн хүрээнд 10 мянган мод суулгах болно. Мөн мод тариалалтын дотоодын нөөц бололцоогоо нэмэгдүүлэхийн тулд ашиглан Шар хад дахь Сургалтын нэгдсэн төвдөө мод үржүүлгийн газар байгуулахаар бэлтгэл ажлаа хангаж байна" гэсэн юм.



## БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Г.САЙХАНБАЯР ЦЭРЭГ ТАТЛАГЫН ЯВЦТАЙ ТАНИЛЦЛАА



Монгол Улсын хэмжээнд 2022 оны I ээлжийн цэрэг татлага эхэлсэн. Тэгвэл нийслэлийн хэмжээнд хугацаат цэргийн албаны татлага өнөөдөр эхэллээ.

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар, ЗХЖШ-ын СБТГ-ын дарга бригадын генерал Ц.Гандорж, НЗДТГ-ын Цэргийн штабын дарга хурандаа Г.Ялалт тэргүүтэй албаныхан өнөөдөр Баянгол дүүргийн цэрэг татлагын явцтай танилцлаа.

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр "Энэ удаагийн

цэрэг татлага Баянгол дүүргийн хэмжээнд хэвийн үргэлжилж байгаагаас гадна цэрэгт явах хүсэлтэй залуусын тоо нэмэгдсэн харагдаж байна. Өнгөрсөн хоёр жилд коронавирусийн цар тахлын улмаас нийслэлд цэрэг татлага явагдаагүй. Энэ жилийн хувьд цэрэг татлагыг нийслэлийн зургаан дүүрэгт явуулж, алслагдсан гурван дүүргийг ирэх намар 2 дугаар ээлжийн цэрэг татлагад хамруулах юм. Мөн энэ удаагийн цэрэг татлагаар иргэдийг зөвхөн хилийн цэрэг болон дотоодын цэргийн анги, салбаруудын хугацаат цэргийн

албанд татна. Зэвсэгт хүчний хувьд 2020 оноос эхлэн жилд нэг удаа хугацаат албандаа цэргүүддээ татдаг болсон бөгөөд Зэвсэгт хүчний ангиудад хуваарилагдсан хугацаат цэргийн алба хаагчид эх орныхоо бүтээн байгуулалтад оролцох боломжтой, хууль эрх зүйн орчин нь бүрдсэн. Тодруулбал, эхний зургаан сарын сургаанд цэргийн бэлтгэл сургалтад бүрэн хамрагдаж, мэргэжлээ эзэмшээд үлдсэн хугацаанд нь гэрээ байгуулж, улс орны стратегийн ач холбогдолтой бусад бүтээн байгуулалтад цалин, урамшуулалтайгаар ажиллах

боломжтой. Мөн Батлан хамгаалах яам, Эрүүл мэндийн яамтай хамтраад цэрэгт эрүүл мэндээр тэнцүүлэх зааврыг шинэчилсэн. Монгол Улсын хэмжээнд цэргийн насны залуусын өвчлөл дээр анализ хийж, ямар өвчлөлийг цэргийн албанаас чөлөөлөх хэмжээнд авч үзэх, түүнийг хэрхэн эрүүлжүүлж, эмчлэх талаар нэгдсэн бодлогоо хэрэгжүүлээд явж байна. Энэ чиглэлээр сургууль болон эрүүл мэндийн байгууллагууд ч анхаарал хандуулж байгаа" гэсэн мэдээллийг өглөө.

Энэ оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагыг дараах сургуулиудад зохион байгуулах юм. Тодруулбал

- Баянгол дүүргийн 96 дугаар сургууль
- Баянзүрх дүүргийн 14 дүгээр сургууль
- Сүхбаатар дүүргийн 31 дүгээр сургууль
- Сонгинохайрхан дүүргийн 83 дугаар сургууль
- Хан-Уул дүүргийн 34 дүгээр сургууль
- Чингэлтэй дүүргийн 5 дугаар сургуульд тус тус цэрэг татлага явагдана.

Түүнчлэн "Ковид-19" цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан дүүрэг бүрийн Цэргийн штаб бэлтгэлээ хангаж, Улсын Онцгой комиссын зөвлөмж, зааврын дагуу цэрэг татлагын байранд ариутгал, халдваргүйтгэл хийн ажиллаж байна. Цэргийн албанд татагдагч нь иргэний үнэмлэх, цэргийн үүрэгтний үнэмлэх, их, дээд сургууль төгссөн диплом зэргийг бүрдүүлж тогтоосон хугацаанд цэрэг татлагын байранд ирэх үүрэгтэй юм.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
12	0

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
38	19

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,100.00	3,110.0
EUR	3,332.0	3,360.0
CNY	471.00	473.00
RUB	39.70	40.00
JPY	24.00	24.80
KRW	2.47	2.49

ЗУРХАЙ



2022.05.06 /БААСАН ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 5

**ЗУНЫ ТЭРГҮҮН ХӨХӨГЧИН МОГОЙ САРЫН ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ ШАР МОРЬ ӨДӨР**

Үс засуулбал:

Бие эрхтний хүч сайжирна

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

05.28-20.10

Барилдлага:

Үл зохилдох

Шүтэн барилдлага:

САНСАР

Суудал: Төмөр

Энэ өдөр үхэр, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, бие энхрийлүүштэй. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба сүм дуганыг сэргээх, газар лусын зан үйл хийх, өр барагдуулах, гэр бүрэхэд сайн. Ургаа мод таслах, газрын ам нээх, гөлөг тэжээхэд муу.

Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогосод баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Модон хохимой өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал бие эрхтний, хүч сайжирна.

## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН
2,273,004 /69.9%/	2,175,662 /66.9%/	1,040,412 32,0%
		125,447 /3,9%/

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
8475 +112	15	8339

## КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол  
Нийт: 515,354,689

Эдгэрсэн  
Нийт: 470,075,418

Нас барсан  
Нийт: 6,269,587

БАГА НАСНЫ ХҮҮХЭДТЭЙ ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧ  
ТА БҮХЭН ХҮҮХЭДЭЭ ЭРТ ИЛҮҮРГЭЛТТ ХАМГААЛАГАЙ!

6-17 НАС

ӨСӨЛТ АЖИЛТ | ҮЗЭГТ | АМАНЫ ХАМГИЙН ЭРҮҮЛ МЭНД

СЭТГЭЭ, ЗАН ТӨРХИЙ АЖИЛТ | ЭМЧИЙН ҮЗЭГТ | ШҮД ЦОРОЛ

СУРЬСГИЙН ИЛҮҮРГЭЛТ | БИЭНИЙ ХЭМЖИЛТ, БИЭНИЙ НИЙГЭМЖИЙН ИЛДЭС | ШҮДНИЙ ГАН АЖИЛТ

ШҮД УГААХ АРГАЧЛАЛ | ЭРҮҮЛ АХИЙН ЗӨВЛӨГӨӨ

Ажлын үнэмлэх, цэргийн үүрэгтний үнэмлэх, их, дээд сургууль төгссөн диплом зэргийг бүрдүүлж тогтоосон хугацаанд цэрэг татлагын байранд ирэх үүрэгтэй юм.

Цахим шууданд

# ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 120 ДУГААР АНГИ МОД ҮРЖҮҮЛГИЙН ГАЗАРТАЙ БОЛЖЭЭ



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт Ерөнхий командлагч У.Хүрэлсүхийн санаачилгаар "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг улс орон даяар өрнүүлээд байна.

Энэхүү үндэсний хөдөлгөөнийг Батлан хамгаалах салбар, Зэвсэгт бүрэлдэхүүн 2022-2030 онд 27 сая модыг зөвхөн тариад орхих бус арчлан хамгаалж, усалж, ургуулах ажлыг хэрэгжүүлнэ.

Манай улсын иргэд, төрийн болон хувийн хэвшлийн алба хаагчид идэвхтэй дэмжин, улс орон даяар эрч хүчээ авч буй энэхүү үндэсний хөдөлгөөнд бид бүхэн нэгдсэнээр Зэвсэгт хүчний ангиудад Мод үржүүлгийн төвийг шинээр ажиллуулж эхэллээ. Тухайлбал, БХЯ, ЗХЖШ-аас төлөвлөсний дагуу Зэвсэгт хүчний 9 ангид Мод үржүүлгийн газар болон Мод үржүүлгийн Сургалтын төвийг шинээр нээж, үйл ажиллагааг нь эхлүүлсээр байгаа юм.

Энд тодруулахад, өнөөдөр буюу Билгийн тооллын Усан бар жилийн Зуны тэргүүн сарын шинийн

5-ны өдрийн морин цагт Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн Мод үржүүлгийн газрын нээлтийн ёслолын ажиллагааг зохион байгуулав.

Уг нээлтэд Зэвсэгт хүчний Жанжин штабын орлогч дарга бригадын генерал Ч.Цогтжаргал, Материал, техникийн газрын дарга бригадын генерал М.Мөнхбаяр болон ЗХЖШ, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал, тус ангийн бие бүрэлдэхүүний төлөөлөл оролцож, мод тарих ажлыг гүйцэтгэлээ.

Нээлтийн ажиллагааны эхэнд Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн Үлээвэр хөгжмийн удирдаач дэслэгч Б.Баттулга морин хуурын, байлдагч Т.Ганболд эвэр бүрээний гоцлолоор урлагийн мэндчилгээ дэвшүүлсэн нь оролцогсдын сэтгэлийг хөгжөөв.

БХЯ, ЗХЖШ-аас энэ оны эхэнд Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн Агро-Экологийн сургуулийн багш нартай хамтран сургагч багш нарыг бэлтгэх сургалтыг амжилттай зохион байгуулсан нь үр дүнгээ өгч буйг уг нээлтийн үеэр бид мэдэрсэн юм.

Нээлтийн ёслолын үеэр тус ангийн Мод үржүүлгийн газрыг хариуцан ажиллаж буй Ойн инженер З.Болдбаатар мод тарихаар ирсэн нийт алба хаагчдад богино хугацааны

сурган зааварлалтыг явуулав.

Үүний дараа Мод үржүүлгийн газарт мод тарихаар ирсэн нийт генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч нар болон ажилтан албан хаагчид нэлээд олон тооны модыг модны үндсээр, мөчрөөр мөн үрээр нь суулган тарьж, нэгэн насны "буян үйлдсэн"-дээ сэтгэл тун хангалуун байлаа.

Мөн уг Мод үржүүлгийн газарт шинээр байгуулсан хиймэл нуур болоод усалтын системийн үйл ажиллагаатай биечлэн танилцаж, тарьсан модоо бодит байдлаар хэрхэн усалж байгааг нь хараад бахархах сэтгэл төрж байсан юм.

Ийнхүү энэ өдрөөс эхлэн Зэвсэгт хүчний 120 дугаар ангиас Нийслэлийн Хан-Уул дүүргийн 13 дугаар хороо, Туул тосгоны нутаг дэвсгэрт шинээр байгуулсан Мод үржүүлгийн газар байнгын ажиллагаанд шилжлээ.

Тус ангийн захирагч хурандаа Л.Дагвасүрэнгийн хэлснээр энэхүү Мод үржүүлгийн газарт 4 га талбайн хөрсийг боловсруулж, модны үр, мөчрийг бэлтгэн, цахилгаан болон усжуулалтын ажлыг бүрэн шийдвэрлэсэн ажээ. Тэд уг Мод үржүүлгийн газартаа зөвхөн энэ онд гэхэд л бургас, улиас, гүйлс, хайлаас, агч, арц зэрэг 6 нэр төрлийн 50000 модыг

тариалах, үржүүлэх зорилтыг дэвшүүлээд байгаа юм.

Энэ үеэр ЗХЖШ-ын орлогч дарга бригадын генерал Ч.Цогтжаргал хэлсэн үгэндээ "Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүн хуулиар хүлээсэн чиг үүргүүдээ амжилттай гүйцэтгэхийн зэрэгцээ байгаль орчноо хайрлан хамгаалж, мод тарьж, экологийн тэнцвэрт байдлыг хадгалан, цөлжилтөөс урьдчилан сэргийлснээр Оршин тогтнохын болон Хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангахад жинтэй хувь нэмэр оруулах болно. Модыг говь, хангай, талын бүсэд зөвхөн тарих бус тэдгээрийг арчлан хамгаалах, усалж тордох, ургуулах ажилд Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүн хамтран, идэвх санаачилгатай ажиллах шаардлага үүсэж байгаа. Энэхүү буянтай ажилд оролцож буй бүхий л алба хаагчдаа талархал илэрхийлье" гэдгийг онцолсон юм.

Тийм ээ! Энэ жилийн хувьд бид бүхэн Зэвсэгт хүчний 017, 186, 310, 311, 336 дугаар ангид Мод үржүүлгийн газрыг шинээр байгуулан үйл ажиллагааг нь хэвшүүлэх болно.

Хурандаа Б.ОТГОНБАЯР

## 2022 ОНЫ НЭГДҮГЭЭР ЭЭЛЖИЙН ЦЭРЭГ ТАТЛАГА ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 34 ДҮГЭЭР СУРГУУЛЬ ДЭЭР ЭХЭЛЛЭЭ

Хан-Уул дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Нийслэлийн хэмжээнд 2022 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлага 05 дугаар сарын 6, 7, 8-ны өдрүүдэд зохион байгуулагдана. Хан-Уул дүүргийн Цэрэг татлагын товчоо дүүргийн ерөнхий боловсролын 34 дүгээр сургууль дээр байрлан ажиллаж байна. Энэ удаагийн ээлжит цэрэг татлагын онцлог нь Хилийн болон дотоодын цэргийг хугацаат цэргийн алба хаагчаар нөхөн хангах юм.



Зарлан дуудах мэдэгдэл хүлээн авсан Хан-Уул дүүргийн цэргийн насны залуучууд Монгол

Улсын Үндсэн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, хугацаат цэргийн албандаа идэвхтэй хамрагдана уу.

## ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 327 ДУГААР АНГИ ХАНДИВЫН АЯНД НЭГДЛЭЭ



Бяцхан үрийнхээ төлөө тэмцэж яваа дэд хурандаа Б.Ууганбаяр, ахлагч С.Ганзаяа нарт эрхэм та бүхэн минь туслаарай. Бусдад тусалсан буян тань буцаж ирэхдээ түм бум болж

ирдэг юм шүү. Бяцхан охин нь тархины үрэвсэл өвчнөөр оношлогдож, БНСУ-д 450 сая төгрөгийн өртөгтэй яаралтай мэс заслын хагалгаанд орох болсны дагуу аав, ээж нь болоод

ЗХЖШ, ОБЕГ, төрлийн цэргийн командлалууд хандивын аяныг өрнүүлж, сайхан сэтгэлт ард түмэн, мөрдэс нэгт нөхдөөсөө тусламжийн гараа сунгахыг уриалсаар байгаа билээ. Энэхүү уриалгын дагуу сайхан сэтгэлт түмэн олон, Зэвсэгт хүчин, Онцгой байдлын байгууллага, хамт олон хандивын аянд нэгдэж, тусламжийн гараа сунгаж байгаад гүн талархал илэрхийлье. Өчигдөр буюу 5 дугаар сарын 04-ний өдөр хурандаа Н.Цэцэнхүү захирагчтай Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн хамт олон 6 сая 6 зуун 30000 мянган төгрөгийн сэтгэлийн хандив илгээснээ гардуулж, бяцхан охиныг хурдан эдгэхийг ерөөлөө. Монголын үрс маш олон болох болтугай.

Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

ЦАХИМ ХАЯГ  
Батлан хамгаалах яам  
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС  
"Соёмбо" сонин  
"Дуулга" студи

\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.  
\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.  
\* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Оффисеруудын ордон Индекс: 10018  
Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn  
Утас: 70001029, 3412 (дотуур)